Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Гадаад худалдаа хариуцсан мэргэжилтэн, Туваанжав Мягмаржав

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох; | | | | | | | |
| 1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан. | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдах | 2026 оны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг боловсруулан ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан зорилго, зорилттой уялдсан "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох" зорилгын хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 11-р сар | 100% |

103

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн 4 бодлогын тэргүүлэх чиглэлтэй бөгөөд эдгээрийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн үр дүн болон төсөл, арга хэмжээ, түүний бодлогын үндэслэл, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн хариуцах байгууллагыг тусгасан. 2026-2030 оны 5 жилийн төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэлийг боловсруулан ажилласан. Хавсралт: 4 файл | | |
| 1.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах; | | | | | | | |
| 2 | Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | - | Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/ | Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай экспортын бараа бүтээгдэхүүний тоо мэдээлэл шинжилгээ хийж, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны төсөөллийг хийж, нэгдсэн макро эдийн засгийн танилцуулгыг нэгтгэн | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулсан. Монгол Улс 2024 онд дэлхийн 160 улстай худалдаа хийлээ. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн ч нүүрсний үнэ буурсан нь экспортын орлогын өсөлтийг хязгаарлалаа. Эдийн засгийн идэвхжилийг дагасан хөрөнгө оруулалт, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр хадгалагдлаа. Урсгал дансны тэнцэл алдагдалтай гарсан ч гадаад бондын орох урсгал нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдлээ. | | |
| 3 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ. | Танилцуулгын тоо | Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн. | 2025 оны III, IV улиралд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга/ | Монгол Улсын эдийн засгийн 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын гадаад худалдааны нөхцөл байдалд дүн шинжилгээ (Macro diagnostics) хийж, улирлын тайланг төлөвлөгөөт хугацаанд боловсруулан, яамны веб хуудсанд байрлуулж, хэвлүүлэн холбогдох байгууллага, судлаачид, | 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар | 100% |

105

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэдэд хүргүүлээд байна. Экспорт 2025 оны 11 сарын байдлаар 13.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар буурлаа.Цаашид, экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах хэдий ч гадаад орчноос шалтгаалан нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний хилийн үнэ буурахаар хүлээгдэж байна. | | |
| 1.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох | | | | | | | |
| 4 | Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана. | Танилцуулгад туссан тоо | 2024 онд батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдолж болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан. | эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /1 танилцуулга | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл болон 2027–2028 оны төсвийн төсөөллийг дагалдуулан, түүхий эдийн үнийн уналтаас үүдэж болзошгүй төсвийн эрсдэлийн тайланг боловсруулсан болно. Уг тайлан нь эрсдэлийг хоёр хувилбараар тооцоолсон. Үүнд: Нэгдүгээр хувилбар: АНУ-ын зүгээс түр хугацаанд хойшлуулсан, БНХАУ-аас бусад улсуудад ногдуулсан харилцан тэнцвэртэй | 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тариф үйлчилж эхлэх бөгөөд бусад улс орнууд хариу тариф нэмэгдүүлэхгүй гэж үзсэн. Хоёрдугаар хувилбар: Дээрхтэй ижил нөхцөл байдал үүсэх ч энэ тохиолдолд бусад улс орнууд хариу арга хэмжээ авч, тариф нэмэгдүүлэхээр тооцсон. | | |
| 5 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. | Танилцуулгын тоо | 2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн. | 2024 оны 7-12 сард танилцуулга бэлтгэсэн байна./6 танилцуулга/ | 2025 оны 1-ээс 12 дугаар сарын тоо мэдээлэлд сар бүр дүгнэлт хийж, сарийн мэдээний танилцуулга бэлдэж удирдлагуудыг мэдээллээр хангаж, яамны цахим хуудсанд байрлуулсан | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 6 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн | Тухай бүр мэдээллээр хангасан байна | Гадаад худалдааны голлох тоо мэдээлэл болох экспорт, импортын өдөр тутмын мэдээлэл, хилээр орсон болон гарсан машин, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ, гадаад валютын ханшийн мэдээллийг өдөр бүр нэгдсэн системд оруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Нийт экспорт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын долоо хонгийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

1ах

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. Мөн уул уурхайн биржийн өмнөх өдрийн арилжаа, дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэл, болон зарим голлох бүтээгдэхүүний экспорт, импортын тоонд дүн шинжилгээ хийж, өдөр бүрийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан | | |
| 1.4. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | | | |
| 7 | Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж танилцуулга бэлтгэн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгана. | Танилцуулгын тоо | - | Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл болон 2027–2028 оны төсвийн төсөөллийг дагалдуулан, түүхий эдийн үнийн уналтаас үүдэж болзошгүй төсвийн эрсдэлийн тайланг боловсруулсан болно. Уг тайлан нь эрсдэлийг хоёр хувилбараар тооцоолсон. Үүнд: Нэгдүгээр хувилбар: АНУ-ын зүгээс түр хугацаанд хойшлуулсан, БНХАУ-аас бусад улсуудад ногдуулсан харилцан тэнцвэртэй тариф үйлчилж эхлэх бөгөөд бусад улс орнууд | 2-р сар, 3-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

/08

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариу тариф нэмэгдүүлэхгүй гэж үзсэн. Хоёрдугаар хувилбар: Дээрхтэй ижил нөхцөл байдал үүсэх ч энэ тохиолдолд бусад улс орнууд хариу арга хэмжээ авч, тариф нэмэгдүүлэхээр тооцсон. | | |
| 1.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх; | | | | | | | |
| 8 | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх; | - | - | - | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан хугацаанд, буюу 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Олон нийтийн хэлэлцүүлэгт 15 байгууллагын 46 төлөөлөгч урилгаар оролцсон. Хуралдааны үеэр Эдийн засаг, хөгжлийн яамнаас эдийн засгийн төлөв байдлын талаар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс макро эдийн засгийн төсөөллийн талаар, Монголбанкнаас инфляцын төлөвийн талаар, Сангийн яамнаас Засгийн газрын өрийн удирдлагын талаарх илтгэлүүдийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлсэн болно. | 2-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 4 файл | | |
| 9 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг 2024.04.30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхэд төсвийн тооцоолол, | 2-р сар, 3-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцууллагыг тухай бүр бэлтгэж, 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлуулсан. 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр олон нийтэд хэлэлцүүлсэн. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байна. | Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байх | - | Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байх | Тухай бүр оролцсон. | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | 100% |

ХЯНАСАН:

Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц. Мөнхдэлгэр /................................................/ Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гадаад худалдаа хариуцсан мэргэжилтэн, Туваанжав Мягмаржав /................................................/ Огноо: 2025.12.15

ТУ32861 6806236 9022010236